



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Бөмбөгөр сумын Засаг даргын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: БНА-2019/7/СТА-ТТЗ

Цахим хуудас: www.audit.mn

Баянхонгор сум 2019 он

Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат

Утас: 99007576 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn

Аудитын менежер: Д.Цэцэгмаа

Утас: 88089024 Цахим хаяг: tsetsegmaadam@audit.gov.mn

Аудитор: Г.Ганчимэг

Утас: 88268424 Цахим хаяг: ganaa_7133@yahoo.com

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт

Агуулга

1	Аудитын гэрчилгээ	3
2	Аудитын тайлан	5
2.1.	Оршил	5
2.2.	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	5
2.3.	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт.....	5
2.4.	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	6
2.5.	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ.....	7
2.6.	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	8
2.7.	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	8
2.8.	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	8
2.8.1	Төсвийн төвлөрүүлэн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагад хийсэн аудитын дүнгийн талаар.....	9
2.8.2	Төсвийн төвлөрүүлэн захирагчийн шатанд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүнгийн талаар	9
2.8.2.1	Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал.	10
2.9.	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	10
2.10.	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	10
2.11.	Шилэн дансны мэдээлэл.....	10
2.12.	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга	10
2.13.	Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл:.....	10
2.14	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	11
3	Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	12

1 Аудитын гэрчилгээ



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**
64101 Номгон, Баянхонгор сум
Утас, факс 70-44-25-84
E-mail: bayankhongor@audit.gov.mn

Г БӨМБӨГӨР СУМЫН ЗАСАГ ДАРГА Н.МӨНХЖАРГАЛ ТАНАА Г

2019.03.25 № 2/162

танай _____-ны № _____-т

Г Аудитын гэрчилгээ Г

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2,3-д заасны дагуу Бөмбөгөр сумын Засаг даргын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулгад санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Бөмбөгөр сумын Засаг даргын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт болон мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Бөмбөгөр сумын Засаг даргын 2018 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга дах үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

2519310

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг хариуцлага

Баянбулаг сумын Засаг дарга нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.МӨНХБАТ

2 Аудитын тайлан

2.1. Оршил

Бөмбөгөр сумын Засаг даргын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг төсвийн төвлөрүүлэн захирагч Сумын Засаг дарга Н.Мөнхжаргалд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2 -д заасны дагуу Бөмбөгөр сумын Засаг даргын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бөмбөгөр сумын Засаг даргын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн төвлөрүүлэн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019.03.19-нөөс 2019.03.22-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019.03.25-ний өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн төвлөрүүлэн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Баянхонгор аймаг дахь төрийн аудитын газрын аудитор Г.Ганчимэг хариуцаж хэрэгжүүлэв.

Бөмбөгөр сумын Засаг даргын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2018 оны 12 дугаар сарын 21-ны өдрийн 144 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Бөмбөгөр сумын Засаг даргын талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Эрхэм зорилго:

Бөмбөгөр сумын Засаг дарга нь Орчин үеийн тэргүүний дэвшилтэт технологи нэвтэрсэн өндөр мэргэжилтэй, чадварлаг боловсон хүчний чадварт түшиглэн төрийн үйлчилгээг үзүүлэх, Монгол Улсын төр засгийн хууль, тогтоомжийг сумын хэмжээнд сурталчлах, төрийн үйлчилгээг ард түмэнд хөнгөн шуурхай хүргэхэд байгууллагын зорилго оршино. гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Бөмбөгөр сумын Засаг даргын удирдлага төсвийн төвлөрүүлэн захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль

- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2018 оны Төсвийн тухай хууль

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гарсан эсэх талаар дараах заалтад тэмдэглэв.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний 8 байгууллага, нэгж 2018 оны санхүүгийн тайландаа аудит хийж баталгаажуулахаас 8 байгууллага аудитад хамрагдсан байна.

Төрийн аудитын байгууллагаас Бөмбөгөр сумын Засаг даргын эрх асуудлын хүрээний байгууллагад санхүүгийн тайлангийн аудит хийсэн хэлбэрийг дараах хүснэгтээр үзүүлэв.

Санхүүгийн тайлангийн аудит хийсэн хэлбэр						
№	Байгууллагын ангилал	Санал дүгнэлт гаргасан	Түүвэрлэсэн	Итгэл үзүүлсэн	Гэрээгээр хийлгэсэн	Аудитад хамрагдаагүй
1	Төсвийн шууд захирагч	3	3		2	
2	ТБӨӨААН					
	Дүн	3	3		2	

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Бөмбөгөр сумын Засаг даргын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Бөмбөгөр сумын Засаг даргын санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг үнэлэхэд 41 буюу мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Бөмбөгөр сумын Засаг даргын санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн Санхүүгийн тооцоолох ХХК-нийн "Aclous" программ хангамж ашигладаг байна.

Бөмбөгөр сумын Засаг даргын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд Дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт Үр нөлөөтэй гэж үзлээ.

Бөмбөгөр сумын Засаг даргын Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд ҮАГ-ын нэгдсэн удирдамжаар Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газраас 2018 оны 11 дүгээр сард хийсэн аудитаар зөрчил дутагдал илрээгүй байна.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад Бөмбөгөр сумын Засаг даргын бэлтгэсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 4 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 4 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр үр дүнгийн тайлангийн нийт зардлын дүнгээс 1,0 хувиар сонгов.

Үр дүнгийн тайлангийн нийт зардлыг материаллаг байдлын суурь үзүүлэлтээр сонгосон нь санхүүгийн тайланг аккурэль сууриар бэлтгэсэнтэй холбоотой юм.

Бөмбөгөр сумын Засаг даргын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үр дүнгийн зардлын дүн 2054144.6 мянган төгрөг бөгөөд түүний 1,0 хувь болох 24194,6 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын төвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын төвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

2.8. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитын явцад хэрэгжүүлэх горим сорилыг төсвийн шатлалд хамаарах байгууллага, нэгж тус бүрээр төлөвлөж хэрэгжүүлсэн бөгөөд аудитын дүн, дүгнэлтийг нэгтгэсэн байдлаар үнэлж, гаргалаа.

Санхүүгийн тайлангийн аудитаар хөндөгдсөн материаллаг биш боловч цаашид санхүүгийн тайлан, тодруулгад материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй зарим асуудлыг толилуулж байна.

Бөмбөгөр сумын Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагын 2018 оны санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн шууд захирагчийн хэмжээнд 23632,2 мянган төгрөгийн залруулагдаагүй зөрчил илэрч, 21782,2 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 1850,0 мянган төгрөгийн зөрчлийг арилгах, дахин давтахгүй байх зөвлөмж өгч, 52668,6 мянган төгрөгийн алдаанд залруулга хийсэн.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн нэгтгэсэн тайланд алдаа, зөрчил илрээгүй болно.

Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудлыг хэрхэн ангилж, шийдвэрлэсэн байдлыг энэ тайлангийн 2.13-т нэгтгэсэн байдлаар үзүүлэв.

Асуудлыг өмнөх төвшинд хийсэн аудитын явцад гарсан асуудал, төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд аудит хийх явцад түүвэрт хамрагдсан асуудлаас илэрсэн асуудал гэсэн ангиллаар үзүүлэв. Үүнд:

2.8.1 Төсвийн төвлөрүүлэн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагад хийсэн аудитын дүнгийн талаар

Асуудал 1: Засаг даргын тамгын газар нь Засаг даргын нөөц хөрөнгөөс 5000,0 мянган төгрөг зарцуулсан ба үүнээс 1850,0 мянган төгрөгийг зориулалт, бусаар зарцуулсан байна.

Шийдэл: Сангийн сайдын 2012 оны 239 дүгээр тушаалаар баталсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам" –ыг хэрэгжүүлж ажиллах зөвлөмж өгөв.

Асуудал 2: СХС-аас зээл авсан иргэдийн авлага, өглөгийг судалгаа болон мөнгөн хөрөнгийн журналаас тулган шалгахад 59408,7 мянган төгрөгийн хугацаа хэтэрсэн зээлээс 31544,0 мянган төгрөгийг төлүүлэхээр шүүхийн шийдвэр гарсан 21782,2 сая төгрөгийн зээлийг төлүүлэх арга хэмжээ аваагүй байна.

Шийдэл: Төлбөрийн акт тогтоосон.

Асуудал 3: Аудитаар Ерөнхий боловсролын нягтлан бодогч нэмэлт санхүүжилтийн орлого 4842,9 мянган төгрөгийг төсвийн гүйцэтгэлийн тайланд тайлагнасан, Цалингийн зардлыг 5466,6 мянган төгрөгөөр үр дүнгийн тайланд дутуу тусгасан, ХХОАТ-ын 18,1 мянган төгрөгийн авлагыг дутуу тусгасан байна.

Асуудал 4: Аудитаар ОНХ-сангаас Тариалан эрхлэлтийн дэмжих сангаас 84366,8 мянган төгрөгийн газар тариалангийн тоног төхөөрөмж худалдан авч 2018 онд 42000,0 мянган төгрөг шилжүүлж үлдэгдэл төлбөрийг 2024 он хүртэл хувааж төлөхөөр гэрээ байгуулсан байхад үлдэгдэл төлбөр болох 42366,8 мянган төгрөгийг санхүүгийн тайланд тусгаагүй байна.

Асуудал 5: ХХОАТ-н 214.3 мянган төгрөгөөр илүү төлж тооцоо үүсгэсэн ба тайланд авлагыг 4.2 мянган төгрөгөөр дутуу тусгасан байна.

Шийдэл: 3, 4, 5 дахь алдааг тус тус залруулсан

2.8.2 Төсвийн төвлөрүүлэн захирагчийн шатанд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүнгийн талаар

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 3 чиглэлээр аудитын 4 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд алдаа, зөрчил илрээгүй болно.

2.8.2.1 Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал

Аудитын явцад алдаа, зөрчил илрээгүй болно.

2.9. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Байхгүй

2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн төвлөрүүлэн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн захирагч нь батлагдсан төсөв, түүний гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулсан, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Бөмбөгөр сумын Засаг даргын чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой 2018 онд хөтөлбөр, арга хэмжээнд зориулан 1873642,8 мянган төгрөгийн төсөв батлагджээ. Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг энэ тайлангийн 4.5-д дэлгэрэнгүй харуулав.

Төсвийн орлогын нийт гүйцэтгэл 1783405,2 мянган төгрөг буюу 99,9 хувь, зардлын нийт гүйцэтгэл 1767690,9 мянган төгрөг буюу 99,1 хувьтай байгаа нь төсөвт байгууллагууд 673,7 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэн, СХС-гаас олгох зээлийг 83200,0 мянган төгрөгөөр баталж зээл олгоогүйтэй холбоотой байна.

Төсвийн орлого, зардлын төлөвлөгөөний биелэлтийг харьяа байгууллагаар нь авч үзвэл төсөвт байгууллагын өөрийн орлогоор 3100,0 мянган төгрөгийг төвлөрүүлэхээс 2698,0 мянган төгрөгийг төвлөрүүлж, орлогын төлөвлөгөө 402,0 мянган төгрөгөөр тасарсан байна.

2.11. Шилэн дансны мэдээлэл

Бөмбөгөр сумын Засаг даргын Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Тус байгууллагын Шилэн дансны хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар зөвлөмж аваагүй байна.

2.13. Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл:

Бөмбөгөр сумын Засаг даргын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар алдаа зөрчил илрээгүй. Харин эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар нийт 23582,2 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрсэн байна.

Төрийн аудитын байгууллагаас аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил түүний шийдвэрлэлийн байдлыг дор нэгтгэн үзүүлэв. Үүнд:

(Мянган төгрөг)

№	Байгууллагын ангилал	Илрүүлэлт						Залруулга	
		Зөрчил		Алдаа		Бүгд дүн		Тоо	Дүн
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн		
1	ТТЗ								
2	ТШЗ	2	23582,2	5	52668,6	7	76250,8	5	52668.6
	Дүн	2	23582,2	5	52668,6	7	76250,8	5	52668.6

Залруулаагүй алдаа, зөрчлийн шийдвэрлэлт

(Мянган төгрөг)

№	Байгууллагын ангилал	Үүнээс: Залруулаагүй алдаа, зөрчлийн шийдвэрлэлт											
		Залруулаагүй алдаа, зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах санал		Хууль хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	ТТЗ												
2	ТШЗ	2	23582,2	1	21782,2			1	1850,0				
	Дүн	2	23582,2	1	21782,2			1	1850,0				

2.14 Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Бөмбөгөр сумын Засаг даргын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Бөмбөгөр сумын Засаг даргын 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн эрхлэх асуудын хүрээний байгууллагад хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн санал дүгнэлтийг нэгтгэн үзүүлэв.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн эрхлэх асуудын хүрээний байгууллагад хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн санал дүгнэлтийг нэгтгэн үзүүлэв

Санал дүгнэлтийн хэлбэр (Тоогоор)

№	Байгууллагын ангилал				Санал дүгнэлт өгөхөөс татгалзсан	Дүн
		Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг		
1	ТШЗ	5				5
2	ТБОӨААН					
	Дүн	5				5

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

3 Аудит хийсэн санхүүгийн тайлан

3.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	/Төгрөгөөр/	
		Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	494363070.40	473308686.70
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	122461502.05	65362784.12
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	122461502.05	65362784.12
3121	Төгрөг	122461502.05	65362784.12
31211	Төрийн сангийн харилцах	122461502.05	65362784.12
33	АВЛАГА	191798787.77	229682933.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	1073404.77	1560217.00
335	Бусад авлага	18000000.00	113612500.00
3351	Байгууллагаас авах авлага	18000000.00	113500000.00
3352	Хувь хүмүүсээс авах авлага	0.00	112500.00
336	Зээлийн авлага	172725383.00	114510216.00
3361	Дотоод эх үүсвэрээс олгосон зээлийн авлага	172725383.00	114510216.00
33612	Хувь хүмүүст олгосон зээл	172725383.00	114510216.00
35	БАРАА МАТЕРИАЛ	178740380.58	178262969.58
351	Түүхий эд материал	95572229.96	109565485.96
35110	Тусгай зориулалттай материал	86481326.96	109380485.96
35130	Эм боох материал	9090903.00	185000.00
35300	Бэлэн бүтээгдэхүүн	25467600.00	7153600.00
354	Хангамжийн материал	54460550.62	48943883.62
35410	Бичиг хэргийн материал	2582740.00	935100.01
35420	Аж ахуйн материал	50247296.62	43670408.61
35440	Түлш, шатах тослох материал	1465200.00	4090800.00
35460	Хүнсний материал	165314.00	247575.00

Бөмбөгөр сумын Засаг даргын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

35600	Мал амьтад	3240000.00	12600000.00
36	НӨӨЦИЙН БАРАА	1362400.00	0.00
36600	Бусад нөөц	1362400.00	
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>2475562045.53</u>	<u>3604623509.57</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	2475562045.53	3604623509.57
392	Биет хөрөнгө	2475407045.33	3530970009.37
39201	Барилга, байгууламж, орон сууц	2,866,562,274.93	3155797561.29
39202	Хуримтлагдсан элэгдэл	(764,461,149.49)	-223657459.85
39203	Авто-тээврийн хэрэгсэл	158,944,126.00	340572558.30
39204	Хуримтлагдсан элэгдэл	(107,140,798.39)	-99194089.99
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	513,379,209.74	609793271.24
39206	Хуримтлагдсан элэгдэл	(347,173,750.85)	-401439430.80
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	215,715,574.90	224562574.90
39208	Хуримтлагдсан элэгдэл	(104,452,283.57)	-122521534.78
39214	Бусад үндсэн хөрөнгө	1,917,100.00	2017100.00
39217	Ном	42,116,742.06	45039459.06
393	Биет бус хөрөнгө	155,000.20	73,653,500.20
39301	Програм хангамж	1,625,000.00	2375000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(1,469,999.80)	-1637499.80
39303	Бусад биет бус хөрөнгө		72916000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>2969925115.93</u>	<u>4077932196.27</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>193190.25</u>	<u>42375279.80</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	193190.25	42375279.80
413	Өглөг	193190.25	42375279.80
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	193190.25	8386.00
4136	Бусад өглөг	0.00	42366893.80
41361	Байгууллагад төлөх өглөг		42366893.80
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>2969731925.68</u>	<u>4035556916.47</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	2969731925.68	4035556916.47
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1589120956.76	1653536956.76
51101	Өмч: - төрийн	1589120956.76	1653536956.76
512	Хуримтлагдсан үр дүн	831108583.16	837032515.34
51210	Өмнөх үеийн үр дүн	772581819.34	831108583.16
51220	Тайлант үеийн үр дүн	58526763.82	5923932.18

Бөмбөгөр сумын Засаг даргын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	549502385.76	1544987444.37
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>2969925115.93</u>	<u>4077932196.27</u>

3.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	2215871484.29	2060068621.87
11	ТАТВАРЫН ОРЛОГО	20850510.73	51645645.37
110	Орлогын албан татвар	14328480.00	35555633.37
1100	Хувь хүний орлогын албан татвар	14328480.00	35555633.37
110002	Үйл ажиллагааны орлого	14328480.00	35555633.37
113	Хөрөнгийн албан татвар	2430000.00	2750000.00
113002	Бууны албан татвар	2430000.00	2750000.00
118	Бусад татвар, төлбөр, хураамж	4092030.73	13340012.00
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	3767030.73	2500262.00
118001	Улсын тэмдэгтийн хураамж	3767030.73	2500262.00
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	0.00	10539750.00
118202	Ан амьтны нөөц ашигласны төлбөр	0.00	10539750.00
1183	Бусад татвар	325000.00	300000.00
118304	Нохойны албан татвар	325000.00	300000.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	397791989.56	355342856.50
120	Нийтлэг татварын бус орлого	397791989.56	355342856.50
120002	Хүүгийн орлого	6597011.94	28264321.70
120003	Торгуулийн орлого	3637000.00	6569563.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	387557977.62	320508971.80
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	60749562.00	5728000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	193167000.00	23144000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	133641415.62	291636971.80
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1797228984.00	1653080120.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1156818914.00	1203423100.00
131003	Төвлөрүүлэх шилжүүлэг	49314.00	0.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1156769600.00	1203423100.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	27344043.00	77260037.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	27344043.00	77260037.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	591342800.00	338268800.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	309471000.00	

Бөмбөгөр сумын Засаг даргын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

132006	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт / аймгаас авсан санхүүгийн дэмжлэг/	270541400.00	286423500.00
132007	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	11330400.00	51845300.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	21723227.00	34128183.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	21723227.00	18971083.00
134003	Нийгмийн даатгалын сангаас эмнэлгүүдэд олгох санхүүжилт		15157100.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2157344720.47	1989632308.88
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2064100420.47	1889855858.88
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1599011406.47	1721629322.57
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	956270063.00	991580947.82
210101	Үндсэн цалин	828696063.00	868860849.82
210102	Нэмэгдэл	51456300.00	50884600.00
210104	Урамшуулал	31794600.00	28370000.00
210105	Гэрээт ажлын хөлс	44323100.00	43465498.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	107833005.78	122223643.70
210201	Тэтгэврийн даатгал	107833005.78	95988594.14
210202	Тэтгэмжийн даатгал		6795348.83
210203	ҮОМШӨ-ний даатгал		4674161.76
210204	Ажилгүйдлийн даатгал		1375322.08
210205	Эрүүл мэндийн даатгал		13390216.89
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	85803960.00	86861017.00
210301	Гэрэл, цахилгаан	11766136.00	13477667.00
210302	Түлш, халаалт	72221224.00	71092500.00
210303	Цэвэр, бохир ус	1816600.00	2290850.00
2104	Хангамж, бараа материалын зардал	67536885.00	67762924.00
210401	Бичиг хэрэг	11138521.00	11523100.00
210402	Тээвэр, шатахуун	33457880.00	44360221.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	5300400.00	2551200.00
210404	Ном, хэвлэл	1215000.00	752300.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	8288208.00	1329900.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2517400.00	1799600.00
210408	Бараа материал акталсны зардал	5619476.00	5446603.00
2105	Нормативт зардал	82953386.00	99948869.69
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	15674085.00	27660610.69
210502	Хоол, хүнс	65040801.00	69792659.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2238500.00	2495600.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4003700.00	6552900.00

Бөмбөгөр сумын Засаг даргын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210601	Багаж, техник, хэрэгсэл	29800.00	29800.00
210604	Урсгал засвар	3973900.00	6523100.00
2107	Томилолт, зочны зардал	5862400.00	6827300.00
210702	Дотоод албан томилолт	5862400.00	6827300.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	72089993.00	29346077.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	70610428.00	24453052.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох		350000.00
210803	Даатгалын үйлчилгээ	1040265.00	853925.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	261800.00	261700.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	45000.00	148000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ		3267000.00
210807	Газрын төлбөр	90000.00	
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	42500.00	12400.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	216658013.69	310525643.36
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	31484867.99	110194818.80
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1138800.00	4841400.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	184034345.70	195489424.56
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	465089014.00	168226536.31
2132	Бусад урсгал шилжүүлэг	155108615.00	165679023.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	22923227.00	18971083.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	24204600.00	25569600.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	23884284.00	54893600.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	47578704.00	65482740.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	36517800.00	762000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	309520314.00	101.00
213401	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт төсөвт байгууллага	309471000.00	0.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	49314.00	101.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	460085.00	2547412.31
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	460085.00	2547412.31
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	93244300.00	99776450.00

Бөмбөгөр сумын Засаг даргын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2200	Дотоод эх үүсвэрээр	93244300.00	99776450.00
223001	Бусад хөрөнгө	93244300.00	99776450.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>58526763.82</u>	<u>70436312.99</u>
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	0.00	64512380.81
225007	Хөрөнгийн дахин үнэлгээний зардал		64512380.81
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	0.00	-64512380.81
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>58526763.82</u>	<u>5923932.18</u>

3.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>2082230068.67</u>	<u>1824287415.07</u>
11	ТАТВАРЫН ОРЛОГО	20850510.73	51645645.37
110	Орлогын албан татвар	14328480.00	35555633.37
1100	Хувь хүний орлогын албан татвар	14328480.00	35555633.37
110002	Үйл ажиллагааны орлого	14328480.00	35555633.37
113	Хөрөнгийн албан татвар	2430000.00	2750000.00
113002	Бууны албан татвар	2430000.00	2750000.00
118	Бусад татвар, төлбөр, хураамж	4092030.73	13340012.00
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	3767030.73	2500262.00
118001	Улсын тэмдэгтийн хураамж	3767030.73	2500262.00
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	0.00	10539750.00
118202	Ан амьтны нөөц ашигласны төлбөр		10539750.00
1183	Бусад татвар	325000.00	300000.00
118304	Нохойны албан татвар	325000.00	300000.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	264150573.94	118801051.70
120	Нийтлэг татварын бус орлого	264150573.94	118801051.70
120002	Хүүгийн орлого	6597011.94	28264321.70
120003	Торгуулийн орлого	3637000.00	6569563.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	253916562.00	83967167.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	60749562.00	60823167.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	193167000.00	23144000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1797228984.00	1653840718.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1156818914.00	1203423100.00
131003	Төвлөрүүлэх шилжүүлэг	49314.00	
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1156769600.00	1203423100.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	27344043.00	91417137.00

Бөмбөгөр сумын Засаг даргын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	27344043.00	91417137.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	591342800.00	338268800.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	309471000.00	
132006	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт / аймгаас авсан санхүүгийн дэмжлэг/	270541400.00	286423500.00
132007	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	11330400.00	51845300.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	21723227.00	20731681.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	21723227.00	20731681.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	1875330850.00	1622893883.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1875330850.00	1622893883.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1410241836.00	1451997048.69
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	955110506.00	973039495.69
210101	Үндсэн цалин	794761806.00	786254561.69
210102	Нэмэгдэл	50884600.00	84207504.00
210104	Урамшуулал	48278100.00	45205281.00
210105	Гэрээт ажлын хөлс	61186000.00	57372149.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	107895600.00	126301700.00
210201	Тэтгэврийн даатгал	107895600.00	87612500.00
210202	Тэтгэмжийн даатгал		9871000.00
210203	ҮОМШӨ-ний даатгал		7684800.00
210204	Ажилгүйдлийн даатгал		1926400.00
210205	Эрүүл мэндийн даатгал		19207000.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	87398146.00	91813665.00
210301	Гэрэл, цахилгаан	13369034.00	13506315.00
210302	Түлш, халаалт	71979012.00	76065350.00
210303	Цэвэр, бохир ус	2050100.00	2242000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	54072549.00	51597700.00
210401	Бичиг хэрэг	8041001.00	9836900.00
210402	Тээвэр, шатахуун	26456340.00	32895100.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	5565400.00	3745900.00
210404	Ном, хэвлэл	2074100.00	741200.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	9290308.00	1399200.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2645400.00	2979400.00
2105	Нормативт зардал	94982330.00	96101328.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	21289500.00	21593808.00
210502	Хоол, хүнс	60716530.00	69874920.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	12976300.00	4632600.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4373200.00	12252900.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	214800.00	81800.00

Бөмбөгөр сумын Засаг даргын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210604	Урсгал засвар	4158400.00	12171100.00
2107	Томилолт, зочны зардал	5617400.00	6827300.00
210702	Дотоод албан томилолт	5617400.00	6827300.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	81967961.00	66532842.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	80382396.00	61041717.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	0.00	350000.00
210803	Даатгалын үйлчилгээ	1040265.00	1018225.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	261800.00	295400.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	45000.00	115000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ		3564000.00
210807	Газрын төлбөр	90000.00	
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	148500.00	148500.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	18824144.00	27530118.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	17350344.00	20804818.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1473800.00	6725300.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	465089014.00	170896834.31
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	0.00	660000.00
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	0.00	660000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	155108615.00	167689321.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	21723227.00	20731681.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	24204600.00	25569600.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	23884284.00	54893600.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	47578704.00	65522440.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	37717800.00	972000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	49314.00	101.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	49314.00	101.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	309931085.00	2547412.31
213401	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт төсөвт байгууллага	309471000.00	0.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	460085.00	2547412.31
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>206899218.67</u>	<u>201393532.07</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	121995000.00	258492250.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	121995000.00	258492250.00
2200	Дотоод эх үүсвэрээр	121995000.00	258492250.00
223001	Бусад хөрөнгө	111244300.00	195276450.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	10750700.00	63215800.00

Бөмбөгөр сумын Засаг даргын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-121995000.00	-258492250.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	84904218.67	-57098717.93
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	37557283.38	122461502.05
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	122461502.05	65362784.12

3.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,589,120,956.76	549,502,385.76	772,581,819.34		2,911,205,161.86
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,589,120,956.76	549,502,385.76	772,581,819.34		2,911,205,161.86
C07	Тайлант үеийн үр дүн			58,526,763.82		58,526,763.82
C08	2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,589,120,956.76	549,502,385.76	831,108,583.16		2,969,731,925.68
D01	2018 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	1,589,120,956.76	549,502,385.76	831,108,583.16	0.00	2,969,731,925.68
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,589,120,956.76	549,502,385.76	831,108,583.16	0.00	2,969,731,925.68
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт		995,485,058.61			995,485,058.61
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	64,416,000.00				64,416,000.00
D08	Тайлант үеийн үр дүн			5923932.18		5,923,932.18
D09	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,653,536,956.76	1,544,987,444.37	837,032,515.34	0.00	4,035,556,916.47

3.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Өмнөх оны		Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1615040900.00	1638278181.00	1783425100.00	1766689902.69
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1469340900.00	1527033881.00	1571266500.00	1571413452.69
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1341593800.00	1399656197.00	1433882700.00	1434039052.69
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	955527900.00	955110506.00	975244000.00	973039495.69
210101	Үндсэн цалин	795179200.00	794761806.00	783116300.00	786254561.69
210102	Нэмэгдэл	50884600.00	50884600.00	85462700.00	84207504.00
210104	Урамшуулал	48278100.00	48278100.00	49233700.00	45205281.00
210105	Гэрээт ажлын хөлс	61186000.00	61186000.00	57431300.00	57372149.00

Бөмбөгөр сумын Засаг даргын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	107895600.00	107895600.00	126301700.00	126301700.00
210201	Тэтгэврийн даатгал	69466300.00	107895600.00	87877300.00	87612500.00
210202	Тэтгэмжийн даатгал	8421700.00		9606200.00	9871000.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	8871500.00		7684800.00	7684800.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1921600.00		1921400.00	1926400.00
210205	Эрүүл мэндийн даатгал	19214500.00		19212000.00	19207000.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	87425800.00	87398146.00	91834400.00	91813665.00
210301	Гэрэл, цахилгаан	13374600.00	13369034.00	13524700.00	13506315.00
210302	Түлш, халаалт	72001100.00	71979012.00	76065700.00	76065350.00
210303	Цэвэр, бохир ус	2050100.00	2050100.00	2244000.00	2242000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	46394900.00	46383241.00	51490000.00	51697700.00
210401	Бичиг хэрэг	8041200.00	8041001.00	9838200.00	9836900.00
210402	Тээвэр, шатахуун	26456400.00	26456340.00	32895100.00	32895100.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	5646100.00	5565400.00	3536300.00	3745900.00
210404	Ном, хэвлэл	2074400.00	2074100.00	841200.00	841200.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1528900.00	1601000.00	1399400.00	1399200.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2647900.00	2645400.00	2979800.00	2979400.00
2105	Нормативт зардал	94983100.00	94982330.00	97044500.00	96101328.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	21289500.00	21289500.00	21614500.00	21593808.00
210502	Хоол, хүнс	60717300.00	60716530.00	70789500.00	69874920.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	12976300.00	12976300.00	4640500.00	4632600.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	8374000.00	8373200.00	32801900.00	32792900.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	2215200.00	2214800.00	3629800.00	3621800.00
210602	Тавилга	2000000.00	2000000.00	8000000.00	8000000.00
210604	Урсгал засвар	4158800.00	4158400.00	21172100.00	21171100.00
2107	Томилолт, зочны зардал	5617500.00	5617400.00	6916800.00	6827300.00
210702	Дотоод албан томилолт	5617500.00	5617400.00	6916800.00	6827300.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	15130500.00	73651630.00	26021400.00	26047846.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	13525500.00	72066065.00	20482600.00	20556721.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох			350000.00	350000.00
210803	Даатгалын үйлчилгээ	1050000.00	1040265.00	1050000.00	1018225.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	271500.00	261800.00	311300.00	295400.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	45000.00	45000.00	115000.00	115000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ			3564000.00	3564000.00
210807	Газрын төлбөр	90000.00	90000.00		

Бөмбөгөр сумын Засаг даргын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	148500.00	148500.00	148500.00	148500.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	20244500.00	20244144.00	26228000.00	29417118.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	18770700.00	18770344.00	19502700.00	22691818.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1473800.00	1473800.00	6725300.00	6725300.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	127747100.00	127377684.00	137383800.00	137374400.00
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	0.00	0.00	30664700.00	30660000.00
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг			30664700.00	30660000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	127747100.00	127377684.00	106719100.00	106714400.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	24574000.00	24204600.00	25569600.00	25569600.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	23884300.00	23884284.00	54893600.00	54893600.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	41571000.00	41571000.00	25279200.00	25279200.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	37717800.00	37717800.00	976700.00	972000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	145700000.0	111244300.0	212158600.0	195276450.0
2200	Дотоод эх үүсвэрээр	145700000.0	111244300.0	212158600.0	195276450.0
223001	Бусад хөрөнгө	145700000.00	111244300.00	212158600.00	195276450.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1615040900.00	1730978163.00	1783425100.00	1701337859.69
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1156769600.00	1156309515.00	1203443000.00	1200875687.69
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1156769600.00	1156309515.00	1203443000.00	1200875687.69
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	311211800.00	320752086.00	416568800.00	416495005.00
132001	Орон нутгийн төсвөөс	299881400.00	309421686.00	364723500.00	364649705.00
132007	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	11330400.00	11330400.00	51845300.00	51845300.00
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	147059500.00	253916562.00	163413300.00	83967167.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2000000.00	60749562.00	2500000.00	60223167.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	107586700.00	193167000.00	160913300.00	23744000.00
1200043	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	37472800.00			
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		27958662.00		120658644.00
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		120658644.00		55306601.00
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	6.00	6.00	6.00	6.00
610001	Төсвийн байгууллага	6.0	6.0	6.00	6.00

Бөмбөгөр сумын Засаг даргын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

62	АЖИЛЛАГСАДЫН ТОО				
620001	Удирдах ажилтан	126.00	126.00	127.00	126.00
620002	Гүйцэтгэх ажилтан	12.00	15.00	12.00	12.00
620003	Үйлчлэх ажилтан	68.00	69.00	69.00	69.00
620004	Гэрээт ажилтан	26.00	22.00	28.00	28.00
620004	Гэрээт ажилтан	20.00	20.00	18.00	17.00
63	СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)	552.00	552.00	613.00	611.00
630	ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД СУРАЛЦАГЧИД				
630001	Төрийн өмчит ЕБС	402.00	402.00	464.00	462.00
631	СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН БАЙГУУЛЛАГА	150.00	150.00	149.00	149.00
631001	Төрийн өмчит СӨБ байгууллага	150.00	150.00	149.00	149.00
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	126.0	127.0	127.0	126.0
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	10.0	10.0	9.00	9.00
650004	СӨБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД)	40.00	40.00	40.00	40.00
650006	Соёл урлагийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮСУ)	3.00	3.00	3.00	3.00
650008	Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮЭМ)	16.00	17.00	17.00	17.00
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	30.00	30.00	33.00	33.00
650010	Гэрээт ажилтан	20.00	20.00	18.00	17.00
650011	Улс төрийн албан хаагч (УТ)	7.00	7.00	7.00	7.00